*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 2023 оны 98 дугаар тушаалын*
*6 дугаар хавсралт*

# ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ, ОЛОН НИЙТ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Б.ЦОЛМОНГЭРЭЛИЙН 2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1: “Улаанбаатар хотын аялал жуулчлалын сурталчилгаанд дэвшилтэд технологийг нэвтрүүлж, контент бэлтгэн, гадаад дотоодод түгээн сурталчилна.” зорилтуудыг хэрэгжүүлэх арга хэмжээ: МУЗГҮАХ-3.3.5.1, НЗДҮАХ-3.4.4** | | | | | | | |
| “Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” 3.4.2.1. Улаанбаатар хотын аялал жуулчлалын сурталчилгааны контент бэлтгэж, гадаад дотоодод түгээн, цахим аялал жуулчлалыг хөгжүүлнэ” зорилтуудыг хэрэгжүүлэх арга хэмжээ: НЗДҮАХ-3.4.4 | | | | | | | |
| Нийслэлийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөө 249, 250, 253, | | | | | | | |
| 1 | **Арга хэмжээ 1.1.** Газраас зохион байгуулж буй эвент арга хэмжээний хэвлэлийн бага хурлыг зохион байгуулах, хэвлэлийн мэдээг бэлтгэх, олон нийтэд хүргэх, сурталчлах | Үйл ажиллагааны Хэрэгжилтийн хувь | 100% | 100% | - Газраас зохион байгуулж буй эвент арга хэмжээг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлан ажиллах ажлын хүрээнд Телевиз, Сайт, Сонин болон мэдээллийн сайтуудаар 8 удаагийн эвент, өдөр тутмын үйл ажиллагаатай холбоотойгоор хэвлэлийн мэдээ бэлтгэж, 11 удаагийн ярилцлага, сурвалжилгад холбогдох албаны хүнийг оролцуулж ажиллаж байна.<br>-Дэлхийн Монголчуудын MGL радиотой хамтран 5 эвент, арга хэмжээг Дэмжигч байгууллага нэвтрүүлэг, Өдөр тутмын мэдээнд цуврал мэдээ мэдээлэл байршуулж, нэвтрүүлэг бэлтгэж ажиллалаа. | 01-06 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2 | **Арга хэмжээ 1.2.** Улаанбаатар хотын танилцуулга сэтгүүл, цахим сэтгүүл, газрын зураг, хөтөч ном зэрэг тараах материал шинэчлэн гаргах | Хэвлэмэл материалын тоо | 15 500 | 18,000 | Нийслэл Улаанбаатар хотыг гадаадад сурталчлах, жуулчдыг хэрэгцээт мэдээллээр хангах, олон улсын үзэсгэлэн арга хэмжээний үеэр тараах зорилгоор Улаанбаатар хотын сурталчилгааны сэтгүүл, хөтөч ном, газрын зураг зэргийг голлох зах зээлийн орнуудын жуулчдад зориулан гадаад хэл дээр хэвлүүлэх ажил хийгдэж байна. Энэ хүрээнд:<br>-Улаанбаатар сэтгүүл /Англи/ -4500 ширхэг;<br>-Улаанбаатар сэтгүүл /Солонгос/ -3000 ширхэг;<br>-Улаанбаатар сэтгүүл /Япон/ -3000 ширхэг;<br>-Улаанбаатар сэтгүүл /Герман/ -3000 ширхэг;<br>-Улаанбаатар сэтгүүл /Орос/ -2000 ширхэг;<br>-Улаанбаатар сэтгүүл /Хятад/- 2000 ширхэг<br>-Улаанбаатар хотын газрын зураг - 9950 ширхэг буюу нийт тоо -27 450 ширхэг сэтгүүл хэвлэгдсэн байна.<br>Нийт хэвлүүлсэн сурталчилгааны материалыг жуулчны мэдээлэл сурталчилгааны төвүүдэд байршуулан жуулчдад мэдээлэл өгөх болон Олон улсын үзэсгэлэн арга хэмжээнд оролцохдоо ашиглаж байна. Мөн Монгол Улсад суугаа Элчин сайдын яамд, консулын газруудад тараан өгөх ажлыг зохион байгуулж байна. | 01-06 | 100 |
| 3 | **Арга хэмжээ 1.3.** Аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ, жуулчдад зориулсан арга хэмжээг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах | Үйл ажиллагааны Хэрэгжилтийн хувь | 100% | 100% | - Скай резорт цанын баазад 2025 оны 02 дугаар сарын 14,15-ны өдрүүдэд зохион байгуулагдсан "Улаанбаатар өвлийн наадам"-ыг угтан хэвлэл мэдээлэл сурталчилгааны чиглэлээр МҮОНРТВ, NTV, TV9 телевизээр шторк, мэдээ сурвалжилга гарч, 24 Сайт, хэвлэл мэдээллийн хэрэгслээр наадмын тухай мэдээ мэдээлэл нийтэлсэн байна. Мөн байгууллагын пэйж хуудсаар шторкийг бүүстэлж 211,590 хүн үзэж, сонирхсон бол наадмын холбогдолтой 18 мэдээ мэдээлэл, постер нийтэлсэн байна. Мөн Дэлхийн монголчуудын MGL радиогоор өдрийн 8 удаагийн давталттай мэдээ ажлын 5 хоног, | 01-06 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Онцлох пост хэсэгт байрлуулж Дэлхийд өнөөдөр нэвтрүүлгээр мэдээлэл бэлтгэсэн.<br><br>- "Улаанбаатар" өвлийн явган алхалтын фестивалийг 2025 оны 2-р сарын 14,15-ны өдрүүдэд зохион байгуулагдаж, хэвлэл мэдээллийн 13 байгууллагад мэдээ нийтлүүлж, арга хэмжээний үеэр Mongol tv, NTVB, Tenger, C1, SBN телевиз хэвлэлийн мэдээ бэлтгэж, тараасан байна.<br><br>- Бүргэдийн баяр 2025 наадмын хүрээнд хэвлэл мэдээлэл, сурталчилгааны чиглэлээр Дэлхийн Монголчуудын MGL радиогийн цахим хуудсанд Онцлох пост хэсэгт байрлуулж, 3-р сарын 03-07 ны хооронд өдрийн 8 удаагийн давталттай мэдээ, Дэлхийд өнөөдөр нэвтрүүлгээр мэдээлэл бэлтгэсэн. Наадмын өдөр МҮОНРТВ, Монгол ТВ, UBS, MNC, Unuudur.mn, 24tsag.mn, gogo.mn, News.mn зэрэг хэвлэл мэдээллийн байгууллагууд газар дээрээс нь мэдээ мэдээлэл бэлтгэсэн бол 48 хэвлэл мэдээллийн сайтад мэдээ мэдээлэл, сурвалжилга, фото мэдээ гаргасан байна. Олон нийтийн цахим сүлжээнд 123,489 хүн үзэж сонирхсон байна<br><br>- "Нарны баяр-Наурызын баяр" арга хэмжээг 2025 оны 03-р сарын 22-ны өдөр жанжин Д.Сүхбаатарын талбайд зохион байгуулж, хэвлэл мэдээлэл сурталчилгааны чиглэлээр 2 удаа давхардсан тоогоор 28 хэвлэл мэдээллийн байгууллагуудаар мэдээ, мэдээлэл бэлтгэж, түгээсэн. Арга хэмжээний үеэр NTV, Tenger tv, Eagle, TV9 телевизүүд газар дээрээс нь нэвтрүүлэг, мэдээ, сурвалжилга бэлтгэсэн. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | - Нийслэлийн Засаг даргын санаачилгаар 2025 оны 04-р сарын 07-14-ний өдрүүдэд зохион байгуулагдсан "Узбек" хоолны өдөрлөг арга хэмжээний маркетинг, сурталчилгааны ажлын хүрээнд хэвлэл мэдээллийн 18 байгууллагад мэдээ мэдээллийг түгээж, арга хэмжээнд МҮОНРТВ, UBS, TV5, NTV, Eagle, Tenger гэх мэт 11 телевиз, сонин, сайт гэх мэт 26 хэвлэлийн байгууллага хүрэлцэн ирж, мэдээ мэдээлэл бэлтгэсэн.<br><br>- "Франц хэлтнүүдийн баяр" Францын соёл, аялал жуулчлалын өдөрлөг 26 дахь жилдээ 04-р сарын 26-ны өдөр жанжин Д.Сүхбаатарын талбайд зохион байгуулагдлаа. Францын соёл, аялал жуулчлалын өдөрлөгийг сурталчлах ажлын хүрээнд хэвлэл мэдээллийн 19 байгууллагаар мэдээ мэдээлэл нийтлэгдсэн байна.<br><br>- Унгар Улсын Будапешт хотод 2025 оны 5 дугаар сарын 11,12-ны өдрүүдэд Улаанбаатар хотын соёлын өдрүүд арга хэмжээний маркетинг сурталчилгааны ажлыг зохион байгуулж, Унгар улсын 5 инфлүнсэрээр дамжуулан цахим орчинд контент бэлтгэн 1 сая орчим хүнд түгээсэн. Арга хэмжээний бэлтгэл ажлын хүрээнд Нийслэлийн Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих төв НӨҮГ-тэй хамтран талбайн тохижуулалтын ажлыг гүйцэтгэж аялал жуулчлалын компаниудын үзэсгэлэнгийн талбай тохижуулалт болон үндсэн талбайн анонс хэвлэлт болон бусад холбогдох тараах материалын хэвлэлтийн ажлыг зохион байгуулсан. Улаанбаатар хотын сурталчилгааны "Улаанбаатар" сэтгүүлийг 1500 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ширхгийг хэвлүүлэн түгээж, Унгар улсад суралцаж буй оюутан залуусыг хамруулан Улаанбаатар хотыг сурталчлах ажлыг зохион байгуулсан. Аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчлах зорилгоор богино хэмжээний видео контентуудыг бэлтгэж олон нийтийн сүлжээнд түгээж, ажилласан.<br><br>–"Улаанбаатар травэл экспо-2025" олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнг МҮОНРТВ, UBS, NTV, EAGLE, C1, Тэнгэр, Өлзий телевиз, Монголын радио, Монголын мэдээ сонин ирж мэдээ мэдээлэл түгээсэн. Нийтдээ 15 мэдээллийн сайтад мэдээ мэдээлэл нийтлэгдсэн байна. Олон нийтийн цахим сүлжээнд 26,214 хүн үзэж сонирхсон байна. Мөн Дэлхийн монголчуудын MGL радиогоор өдрийн 8 удаагийн давталттай мэдээг ажлын 5 хоног, онцлох пост хэсэгт байрлуулж Дэлхийд өнөөдөр нэвтрүүлгээр мэдээлэл бэлтгэсэн. | | |
| 4 | **Арга хэмжээ-1.4.**<br>Улаанбаатар хотын аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг гадаад, дотоодын олон нийтийн сүлжээгээр сурталчлан таниулна. | Үйл ажиллагааны Хэрэгжилтийн хувь | 100% | 100% | Байгууллагын цахим хуудас www.tourism.ub.gov.mn, www.visitulaanbaatar.net болон газрын facebook, instagram, youtube цахим сүлжээнд давхардсан тоогоор 830 мэдээ мэдээлэл, фото зураг, дүрс бичлэг оруулж 1,589,674 хандалт авч үйл ажиллагаагаа олон нийтэд нээлттэй хүргэн ажилласан. Тухайлбал:<br>www.tourism.ub.gov.mn цахим хуудсанд 118 мэдээ, мэдээлэл оруулж, хандалтын тоо 5,187,<br>www.visitulaanbaatar.net цахим хуудсанд 57 мэдээ мэдээлэл, фото зураг, дүрс бичлэг оруулж хандалтын тоо 18,980<br>https://www.facebook.com/UlaanbaatarTourism цахим хуудсанд 579 мэдээ мэдээлэл, фото зураг, дүрс бичлэг оруулж дагагчдын тоо 36,061 хандалтын тоо 1,577,165 | 01-06 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | https://www.instagram.com/visit.ulaanbaatar/ цахим хуудсанд 159 фото зураг, дүрс бичлэг оруулж дагагчдын тоо 389, хандалтын тоо 2,780 https://www.youtube.com/channel/UCjnuixwnzpDZzieEnhXfPFA цахим хуудсанд 36 дүрс бичлэг оруулж дагагчдын тоо 496, хандалтын тоо 5,562 байна. | | |
| 5 | **Арга хэмжээ-1.5:** Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, түүнтэй холбогдох бодлогын баримт бичгийн биелэлтийг цаг тухай бүрт гаргах | | | | Байгууллагын https://tourism.ub.gov.mn/ цахим хуудас болон мэдээллийн самбарт эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүнг эмх цэгцтэй, ойлгомжтой байдлаар байршуулан, байнга шинэчилж, баяжуулалтыг хийж хөтлөн явуулдаг. НАЖГ-ын үйл ажиллагаатай холбоотой арга хэмжээнээс 830 мэдээ, мэдээлэл бэлтгэж газрын веб сайт болон пэйж хуудаст нийтэлж, эдгээр мэдээ мэдээллийг 7 телевиз, өдөр тутмын сонин 5, 17 веб сайтад давхардсан тоогоор 118 мэдээ нийтлүүлж ажилласан байна. Түүнчлэн телевизүүдээр НАЖГ-ын үйл ажиллагаатай холбоотой 25 мэдээ, нэвтрүүлэг цацагдсан байна.<br>- Түүнчлэн Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай, Шилэн дансны тухай хууль, Авлигын эсрэг үйл ажиллагааны дагуу Эрхэм зорилго, үйл ажиллагааны зорилт, зорилго, тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх мэдээллийг www.shilen.gov.mn болон https://tourism.ub.gov.mn/?cat=27–нд сайтад байршуулан ил тод байдлыг хангаж ажилласан. | 01-06 | 100 |
| **Зорилт 2: Улаанбаатар хотын аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг олон улсад сурталчлах, зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ: НЗДҮАХ-3.4.6** | | | | | | | |
| 6 | **Арга хэмжээ 2.1.** | | 100% | 100% | -"Бүргэдийн баяр 2025" наадмын хүрээнд хэвлэл мэдээлэл, сурталчилгааны чиглэлээр | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Гадаад, дотоодын хэвлэл мэдээллийн байгууллага, дэлхийд алдартай инфлүнсэрүүдээр Улаанбаатар хотын аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчлах | Үйл ажиллагааны Хэрэгжилтийн хувь | | | Аяллын тойрог нэвтрүүлгийн хөтлөгч Ган-Өлзийтэй хамтран контент бэлтгүүлж, 940 000 гаруй хандалттай байна.<br><br>-Унгар Улсын Будапешт хотод 2025 оны 05 дугаар сарын 11,12-ны өдрүүдэд Улаанбаатар хотын соёлын өдрүүд арга хэмжээний маркетинг сурталчилгааны ажлыг зохион байгуулж, Унгар улсын 5 инфлүнсэрээр дамжуулан цахим орчинд контент бэлтгэн 1 сая орчим хүнд түгээсэн. | 01-06 | 100 |
| **Зорилт 3: Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилтын хүрээнд:** | | | | | | | |
| 7 | **Арга хэмжээ 3.1**<br>Албан хэрэг хөтлөлтийг заавар, дүрэм, журам, стандартын дагуу зохион бүрдүүлэн хөтлөх, ирсэн бичгийг цаг хугацаанд нь шийдвэрлэх | Шийдвэрлэлт-ийн хувиар | 100% | 100% | Байгууллагаас зохион байгуулж эвент арга хэмжээний үеэр хэвлэл мэдээллийн байгууллагаар нэвтрүүлэг хийлгэх, мэдээ мэдээлэл бэлтгүүлж, цацуулахтай холбоотой 6 албан бичиг төлөвлөн холбогдох байгууллагад хүргүүлж ажилласан. | 01-06 | 100 |
| 8 | **Арга хэмжээ 3.2**<br>Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн өргөдөл хүсэлт, санал гомдлыг түргэн шуурхай, нэг мөр эцэслэн шийдвэрлэх | Шийдвэрлэлт-ийн хугацаагаар | 100% | 100% | Иргэд, аж ахуй нэгжээс ирүүлсэн өргөдөл гомдол, хүсэлт, саналыг түргэн шуурхай эцэслэн шийдвэрлэж ажиллаж байна. | 01-06 | 100 |
| 9 | **Арга хэмжээ 3.3**<br>“Архив, албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”-ын хүрээнд тавигдах стандарт, бүрдэл, шаардлагын дагуу 2024 оны архивын | Хүлээлгэн өгсөн тоо | 4 | 4 | Албан хэрэг хөтлөлтийн журам, Архивын тухай хууль, холбогдох дүрэм журмыг баримтлан, хариуцсан ажлын чиглэлээр хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг гарган, бичиг баримтыг стандартын дагуу 4 хавтас материал, цахим архивын хамт архивлаж ажиллалаа. | 01-03 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | материалыг хүлээлгэн өгнө. | | | | | | |
| 10 | **Арга хэмжээ 3.4**<br>Байгууллагын Ёс зүйн зөвлөлийн ажлыг зохион байгуулах | Шийдвэрлэлт-ийн хувиар | 100% | 100% | -Нийслэлийн Аялал жуулчлалын газрын Ёс зүйн дэд хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, ёс зүйн дэд хорооны даргаар батлуулсан. Ажлын төлөвлөгөөнд 13 арга хэмжээг тусгаж, төрийн албаны нэгдсэн системд хандах эрхийг нээлгэн биелэлтийг хангаж ажиллаж байна.<br><br>-Төрийн албаны төв зөвлөлөөс улсын хэмжээнд зохион байгуулж буй 4-11 сургалтад байгууллагын албан хаагчид цахим сургалтад долоо хоног бүрийн пүрэв гаригт хамрагдан мэдлэг, чадвараа нэмэгдүүлэн ажиллаж байна.<br><br>-Батлагдсан төлөвлөгөөний дагуу Төрийн албаны ёс зүйн тухай хуулийн танилцуулах сургалт, сурталчлах ажлыг нийт албан хаагчдын дунд зохион байгуулав.<br><br>-Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, ёс зүйн дэд хорооны ажиллах журмыг гарын авлага болгон хэвлэмэл ном хэлбэрээр шинээр томилогдон ажиллаж байгаа 4 албан хаагчдад хэвлэж өгөв.<br><br>-Байгууллагын албан хаагчдыг ёс зүйн зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиг үүргийг хэрэгжүүлэх, албан хаагчдын сургалтын хэрэгцээ шаардлагыг тодорхойлох зорилгоор Ёс зүйн дэд хорооноос “Ажилтны ёс зүй, харилцаа хандлага”-ын судалгааг 13 асуулгын хүрээнд боловсруулж, Google forms программ ашиглан байгууллагын 18 албан хаагч хамрагдаж, өөрсдийн тулгамдаж буй хэрэгцээний талаар санал | 01-06 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | асуулгад хариулт өгсөн байна. Судалгааны үр дүнг нийт албан хаагчдад танилцуулсан. Уг судалгаагаар албан хаагчид харилцаа хандлага, байгууллагын соёл гэсэн чиглэлээр сургалтад хамрагдах хүсэлтэй байсан тул энэ чиглэлийн сургалт, нөлөөллийн чиглэлийн арга хэмжээнүүдийн II-IV улиралд төлөвлөгөөний дагуу зохион байгуулна.<br><br>- Хамт олноос харилцаа хандлагын судалгаа авч, сэтгэл зүйн сургалт зохион байгуулж боловсруулж ажилласан.<br><br>-Энэ хүрээнд Байгууллагын ёс зүйн зөвлөлөөс албан хаагчдын харилцаа хандлагыг сайжруулах, стрессгүй ажлын байр бий болгох зорилгоор Сэтгэл зүйч Р.Бадамцэцэгтэй хамтран "Хувь хүний сэтгэлзүйн онцлог, өөрийгөө танин мэдэхүй, "Хосын харилцаа", "Хүүхдийн хүмүүжил" сэдвээр сургалт зохион байгуулсан.<br><br>-Гадаад дотоодын иргэд, жуулчдад хэрэгцээт мэдээ мэдээллээр үйлчилгээ үзүүлэх зорилготой Жуулчны мэдээлэл сурталчилгааны төвүүдээр дамжуулан үйлчилгээ авч буй иргэд, жуулчдаас тогтмол сэтгэл ханамжийн судалгаа авч ажиллаж байна.<br><br>-Байгууллагын хамт олны дунд Ёс зүйн тухай хууль, дагалдах журмын хүрээнд танин мэдэхүйн тэмцээн зохион байгуулсан.<br><br>-Байгууллагын хамт олны харилцаа хандлагыг сайжруулах чиглэлээр 2025.06.04-ний 9 цагт "Ёс зүй, байгууллагын соёл" сэдвээр сургалт зохион байгууллаа. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 11 | **Арга хэмжээ 3.5.** Арга хэмжээний үеэр фото зураг авах, зургийн санг нэмэгдүүлэх, ашиглах | Шийдвэрлэлт-ийн хувиар | 100% | 100% | Байгууллагаас зохион байгуулж байгаа өдөр тутмын үйл явдал болон 8 удаагийн эвент арга хэмжээний үеэр фото зураг авч 8 хавтас бүхий 19 758 ширхэг зургийн сан үүсгэж ажиллаж байна | 01-06 | 100 |
| 12 | **Арга хэмжээ 3.6.** Арга хэмжээний видео шторк, контентын санг нэмэгдүүлэх, ашиглах | Шийдвэрлэлт-ийн хувиар | 100% | 100% | Байгууллагаас зохион байгуулж байгаа өдөр тутмын үйл явдал болон 8 удаагийн эвент арга хэмжээний үеэр бүтээсэн контент, шторк бүхий 8 хавтас бүхий 1200 ширхэг видео бичлэгийг сан үүсгэж ажиллаж байна | 01-06 | 100 |
| 13 | **Арга хэмжээ 3.7.** Хариуцсан ажлын хүрээнд холбогдох бүх төрлийн судалгааг гаргаж, мэдээллийн сан үүсгэх | Шийдвэрлэлт-ийн хувиар | 100% | 100% | - Олон нийтийн мэдээллийн хэрэгслүүдийн судалгаа, үнийн мэдээллийг авч мэдээллийн сан үүсгэж байна.<br><br>- Олон нийтийн цахим сүлжээгээр маркетинг сурталчилгааг эрчимжүүлэх ажлын хүрээнд Гадаадад амьдардаг Монголчуудын FB 78 группт элсэж, мэдээ мэдээлэл хүргэх ажлыг зохион байгуулж байна.<br><br>- 2025 онд тус байгууллагаас хэвлүүлэх материалын судалгааг гаргаж, судалгааны дагуу захирамж төлөвлөн, хэвлүүлэн, гаргасан төлөвлөгөөний дагуу олон улсын чанартай арга хэмжээ, үзэсгэлэн, дотоодын эвент арга хэмжээнүүд болон Гадаад хэргийн яамаар дамжуулан элчин сайдын яам, консулын газруудаар тараах ажлыг зохион байгуулж байна.<br><br>- Тус онд зохион байгуулагдсан 8 эвент арга хэмжээний үеэр хэвлэл мэдээллийн байгууллагын шууд дамжуулалт, реклам сурталчилгааны үнийн саналыг авч, судалгаа хийсэн. | 01-06 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | - Мөн тус арга хэмжээний үеэр Нийслэлийн засаг дарга болон, орлогч дарга, Нийслэлийн Аялал жуулчлалын газрын даргын хэлэх үгийг бичиж бэлтгэсэн.<br><br>- 2025 онд тус байгууллагаас хэвлүүлэх материалын судалгааг гаргаж, судалгааны дагуу захирамж төлөвлөн, гаргасан төлөвлөгөөний дагуу хэвлэлийн компаниудын үнийн судалгааг авч нэгтгэн, хэвлэмэл материалд орох нэмэлт мэдээллүүдийг нэгтгэж, орчуулгын ажил хийлгэсэн. | | |
| **Зорилт 4: Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд:** | | | | | | | |
| 14 | **Арга хэмжээ 4.1**<br>Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжид заасан чиг үүргийг хэрэгжүүлэх, Төрийн албаны хууль болон төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг мөрдөн ажиллах хэрэгжүүлж ажиллах | Үйл ажиллагааны Хэрэгжилтийн хувь | 100% | 100% | Ажил мэргэжилтэй холбоотой хууль, тогтоол, захирамж, журам болон байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, дотоод ажил үүргийн хуваарийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж, Албан хэрэг хөтлөлтийн журам, Архивын тухай хууль, холбогдох дүрэм, журмыг төрийн албаны стандартыг хэрэгжүүлэн анхаарч ажиллаж байна. Өөрийн ажил үүрэгтэй холбоотой өгсөн үүрэг даалгавар, шинэ мэдээ мэдээллийг удирдлагуудад танилцуулан, тухай бүр үнэн зөв мэдээллээр хангаж биелэлтийг гарган ажиллаж байна. | 01-06 | 100 |
| 15 | **Арга хэмжээ 4.2**<br>Бодлогын баримт бичгийн тайлан өөрт хамааралтай гаргаж тайлагнах | Үйл ажиллагааны Хэрэгжилтийн хувь | 100% | 100% | Нийслэлийн Засаг даргын мөрийн хөтөлбөр болон Нийслэлийн хөгжлийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан заалт болон Газрын даргын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, Засаг даргатай байгуулсан хариуцлагын гэрээ зэрэг бодлогын баримт бичигт өөрийн албан тушаалын чиг үүрэгт хамаарах заалтын биелэлтийг тухай бүрд гаргаж тайлагнасан.<br><br>Мөн гадаад сурталчилгааны ажил зохион байгуулах тухай захирамжийн хүрээнд гадаад | 01-06 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | сурталчилгааны материал хэвлүүлэхтэй холбоотой тайланг хуулийн хугацаанд нь гаргаж Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн. | | |
| 16 | **Арга хэмжээ 4.3** Найрсаг Улаанбаатар хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллах | Үйл ажиллагааны Хэрэгжилтийн хувь | 100% | 100% | Найрсаг Улаанбаатар хөтөлбөрийн хүрээнд авч хэрэгжүүлэх ажлаас өөрийн албан тушаалын чиг үүрэгт хамаарах заалтын биелэлтийг тухай бүрд гаргаж тайлагнасан. | 01-06 | 100 |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээ**

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | **Арга хэмжээ 1.** Монгол бичгийн чадвараа дээшлүүлсэн байна | Үйл ажиллагааны Хэрэгжилтийн хувь | 100% | 100% | 2025 оны 01-р сараас эхлэн төрийн албан хэрэг хөтлөлтийг Монгол бичгээр давхар эрхлэх болсонтой холбоотойгоор мэдлэг чадвараа дээшлүүлэхэд анхаарч ажиллаж байна. | 01-02 | 100 |
| 2 | **Арга хэмжээ 2.** Байгууллагаас санал болгох 2 удаагийн сургалтад хамрагдана | Үйл ажиллагааны Хэрэгжилтийн хувь | 100% | 100% | -Төрийн албаны төв зөвлөлөөс улсын хэмжээнд зохион байгуулж буй 4-11 сургалтад байгууллагын албан хаагчид цахим сургалтад долоо хоног бүрийн пүрэв гаригт хамрагдан мэдлэг, чадвараа нэмэгдүүлэн ажиллаж байна.<br><br>- Энэ хүрээнд Байгууллагын ёс зүйн зөвлөлөөс албан хаагчдын харилцаа хандлагыг сайжруулах, стрессгүй ажлын байр бий болгох зорилгоор Сэтгэл зүйч Р.Бадамцэцэгтэй хамтран “Хувь хүний сэтгэлзүйн онцлог, өөрийгөө танин мэдэхүй, “Хосын харилцаа”, “Хүүхдийн хүмүүжил” сэдвээр сургалт зохион байгуулсан. | 02-06 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | -Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан Бүсчилсэн хөгжил, төрийн албаны манлайлал сэдэвт сургалт, хэлэлцүүлэгт хамрагдсан. | | |
| 3 | **Арга хэмжээ 3.** Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь сэдэвт богино хугацааны сургалтад хамрагдана | Үйл ажиллагааны Хэрэгжилтийн хувь | 100% | 100% | -Төрийн албан хаагчийн ёс зүйн асуудал, хууль тогтоомжийн хэрэгжилт<br>-Төрийн албан хаагчийн ёс зүй, манлайлал,<br>-Төрийн албаны шинэтгэл- ёс зүй сэдэвт сургалт, хэлэлцүүлэгт оролцсон. | 01-06 | 100 |

**Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт**

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | **Үүрэг даалгавар1.** Нүүдэлчин өвлийн наадмын үеэр зохион байгуулагдсан Өвлийн дээлтэй монгол жагсаалын хэвлэл, сурталчилгааны ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагааны Хэрэгжилтийн хувь | - | 100% | 2025 оны 02-р сарын 17-ны өдөр Нүүдэлчин өвлийн наадмын үеэр зохион байгуулсан “Өвлийн дээлтэй Монгол” жагсаалын хэвлэл, сурталчилгааны ажлыг зохион байгуулах ажлын хүрээнд байгууллагын цахим хуудсууд болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээ мэдээлэл бэлдэж түгээж ажилласан. | 02-02 | 100 |
| 2 | **Үүрэг даалгавар2.** “Наурызын баяр- Нарны баяр” арга хэмжээний хэвлэл мэдээлэл, маркетингийн ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагааны Хэрэгжилтийн хувь | - | 100% | Нийслэлийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын газрын даргын үүрэг болгосны дагуу 2025 оны 03-р сарын 20-ны өдөр жанжин Д.Сүхбаатарын талбайд зохион байгууллаа. Энэ хүрээнд арга хэмжээний хэвлэл мэдээлэл, маркетинг сурталчилгааны ажлыг зохион байгуулж арга хэмжээний өмнө байгууллагын цахим хуудас болон хэвлэл мэдээллийн байгууллагуудад мэдээ мэдээлэл бэлтгэж түгээх болон тухайн өдрүүдэд хэвлэл мэдээллийн байгууллагад мэдээлэл өгч, ярилцлага, сурвалжилгад оролцох албаны хүмүүсийг зохион байгуулж ажиллалаа. | 03-03 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3 | **Үүрэг даалгавар 3.** Узбек хоолны өдөрлөг арга хэмжээний хэвлэл мэдээлэл, маркетингийн ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагааны Хэрэгжилтийн хувь | - | 100% | Монголд зочлох жилийн хүрээнд Улаанбаатар хотын аялал жуулчлалыг хөгжүүлэх, жуулчны улирлын хамаарлыг бууруулах, шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг бий болгох, хотын соёлыг түгээн дэлгэрүүлэх, иргэдийн амралт чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/176 дугаар захирамж, тус газрын даргын 2025 оны А/06 дугаар тушаалын дагуу 2025 оны 04 дүгээр сарын 08-13-ны өдрүүдэд “UB food-2025” олон улсын хоолны өдөрлөгийг жанжин Д.Сүхбаатарын талбайд зохион байгууллаа. Тухайлбал:<br>- Асрын гадна, доторх хэвлэл<br>- Такс/бугуйвч/ хэвлэлт,<br>- Улаан туузан хаалт түрээс,<br>- Стэнд түрээс<br>- Арга хэмжээний зохион байгуулалтад оролцох албан хаагчдын хувцсан дээрх хэвлэл<br>- Мандат хэвлэлт зэрэг хэвлэлтийн ажлын эх бэлтгэл, дизайн, хэвлэлийн ажлыг зохион байгуулсан.<br><br>Тус арга хэмжээг сурталчлах ажлын хүрээнд байгууллагын цахим хуудас болон хэвлэл мэдээллийн байгууллагуудад мэдээ мэдээлэл бэлтгэж түгээх болон тухайн өдрүүдэд хэвлэл мэдээллийн байгууллагад мэдээлэл өгч, ярилцлага, сурвалжилгад оролцох албаны хүмүүсийг зохион байгуулж ажиллалаа. | 03-04 | 100 |
| 4 | **Үүрэг даалгавар 4.** МВА-ийн тоглолтын хуваарийг судалж, танилцуулах | Үйл ажиллагааны Хэрэгжилтийн хувь | - | 100% | “Узбек хоолны өдөрлөг”-ийн үеэр олон нийтийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх ажлын хүрээнд дэлгэцээр спортын уралдаан цацах чиглэлээр спортын телевизүүдийн судалгаа гаргаж, Пример спорт суваг телевизэд албан бичиг илгээж, телевизийн хөтөлбөрийг | 04-04 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | урьдчилж авах болон зөвшөөрөл авч ажиллалаа. | | |
| 5 | **Үүрэг даалгавар 5.** Улаанбаатар хотын соёлын өдрүүд арга хэмжээний хэвлэл, маркетинг сурталчилгааны ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагааны Хэрэгжилтийн хувь | - | 100% | Унгар Улсын Будапешт хотод 2025 оны 05 дугаар сарын 11,12-ны өдрүүдэд Улаанбаатар хотын соёлын өдрүүд арга хэмжээний маркетинг сурталчилгааны ажлыг зохион байгуулж, Унгар улсын 5 инфлүнсэрээр дамжуулан цахим орчинд контент бэлтгэн 1 сая орчим хүнд түгээсэн.<br><br>Арга хэмжээний бэлтгэл ажлын хүрээнд Нийслэлийн Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих төв НӨҮГ-тэй хамтран талбайн тохижуулалтын ажлыг гүйцэтгэж аялал жуулчлалын компаниудын үзэсгэлэнгийн талбай тохижуулалт болон үндсэн талбайн анонс хэвлэлт болон бусад холбогдох тараах материалын хэвлэлтийн ажлыг зохион байгуулсан. Улаанбаатар хотын сурталчилгааны "Улаанбаатар" сэтгүүлийг 1500 ширхгийг хэвлүүлэн тараасан. Унгар Улсад суралцаж буй оюутан залуусыг хамруулан Улаанбаатар хотыг сурталчлах ажлыг зохион байгуулсан. Аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчлах зорилгоор богино хэмжээний видео контентуудыг бэлтгэж олон нийтийн сүлжээнд түгээж, ажилласан | 04-05 | 100 |
| 6 | **Үүрэг даалгавар 6.** Нийслэлийн нийтийн тээврийн газартай хамтран Улаанбаатар хотын аялал жуулчлалын сурталчлах ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагааны Хэрэгжилтийн хувь | - | 100% | Визит Улаанбаатар брэндийг хэрэглээнд нэвтрүүлэх, үйл ажиллагаандаа тогтмол ашиглах үүднээс Нийтийн тээврийн бодлогын газар, Улаанбаатар смарт карт ХХК-д албан хүсэлт өгч зорчигчийн картад хэвлүүлэх хүсэлтийг тавьж Чингис хаан олон улсын нисэх буудлаас гадаад дотоодын жуулчдад үйлчлэх нийтийн тээврийн 7 автобусанд Визит Улаанбаатар, Go Mongolia логог байршуулах ажлыг зохион байгууллаа. Мөн автобусанд | 05-06 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | мэдээлэл өгөх зориулалттай дэлгэцээр гаргах Улаанбаатар хотын танилцуулга, энэ онд зохион байгуулагдах эвентийн танилцуулга, Go Mongolia -ийн богино бичлэгүүдийг нэгтгэж, илгээж ажиллалаа. | | |
| 7 | **Үүрэг даалгавар 7.** Улаанбаатар хотын аялал жуулчлалыг сурталчлах ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагааны Хэрэгжилтийн хувь | - | 100% | Польш улсад суугаа Монгол Улсын Элчин сайдын яамнаас хүсэлт тавьсны дагуу Улаанбаатар хотын зурагнуудыг илгээж, сонгогдсон зурагнуудыг өндөр чанартайгаар хэвлүүлэх ажилд хамтарч ажиллалаа. | 04-04 | 100 |
| 8 | **Үүрэг даалгавар 8.** Олон улсын арга хэмжээнд Улаанбаатар хотын аялал жуулчлалыг сурталчлах ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагааны Хэрэгжилтийн хувь | - | 100% | Улаанбаатар хотын аялал жуулчлалыг сурталчлах ажлын хүрээнд Гадаад харилцааны яамнаас хүсэлт тавьсны дагуу Монгол улс, Улаанбаатар хотын зурагнуудаас сонгож, Визит Улаанбаатар, Go Mongolia логог байршуулж, богино хэмжээний бичлэг, танилцуулга видеонуудыг нэгтгэж илгээлээ. | 05-05 | 100 |
| 9 | **Үүрэг даалгавар 10.** Олон улсын арга хэмжээнд Улаанбаатар хотын аялал жуулчлалыг сурталчлах ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагааны Хэрэгжилтийн хувь | - | 100% | Азийн үнэт цаасны 30 дахь удаагийн чуулганы нэгдсэн хуралдаанд оролцох олон улсын зочид төлөөлөгчдөд Монгол улс, Улаанбаатар хотыг сурталчлах ажлын хүрээнд ашиглах эрхтэй гэрэл зураг, видео контентуудыг нэгтгэн өгч ажиллалаа. | 05-05 | 100 |
| 10 | **Үүрэг даалгавар 11.** Эвент арга хэмжээний маркетинг сурталчилгааны ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагааны Хэрэгжилтийн хувь | - | 100% | "Улаанбаатар травел экспо" дотоодын аялал жуулчлалын үзэсгэлэнгийн маркетинг сурталчилгааны ажлын хүрээнд байгууллагын цахим хуудсыг дагасан оролцогчдод тараах гарын бэлэг гар утасны карт холдер байхаар төлөвлөж, Визит Улаанбаатар логог байршуулах ажлыг зохион байгууллаа. Мөн байгууллагын стэнд тохижуулалтын ажлыг зохион байгуулж, лед стэндний хэмжээнд тохирсон Улаанбаатар хотын аялал жуулчлалын контентыг засаж ажиллалаа. | 05-05 | 100 |
| 11 | **Үүрэг даалгавар 12.** | Үйл ажиллагааны | - | 100% | Монгол Улсад нисэх хүчин үүсэж хөгжсөний ойд зориулан Улаанбаатар хотын танилцуулга, энэ | 05-05 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Иргэний нисэхийн ойд зориулан постер, шторк бэлтгэж холбогдох хүнд өгөх | Хэрэгжилтийн хувь | | | онд зохион байгуулагдах эвентийн танилцуулга, "Go Mongolia"-ийн богино бичлэгүүдийг нэгтгэж, илгээж ажиллалаа. | | |
| 12 | **Үүрэг даалгавар 13.** "Мэжик дрийм" парадын ажлыг сурталчилж ажиллах | Үйл ажиллагааны Хэрэгжилтийн хувь | - | 100% | НЗДТГ-аас зохион байгуулсан "Монгол хүүхэд 2025" арга хэмжээний үеэр тус газраас зохион байгуулсан "Мэжик дрийм" баярын жагсаалыг сурталчилж ажиллав. | 06-06 | 100 |
| 13 | **Үүрэг даалгавар 14.** Мэргэжлийн хөтөч тайлбарлагчийн үнэмлэх олгох шалгалтыг сурталчилж ажиллав. | Үйл ажиллагааны Хэрэгжилтийн хувь | - | 100% | Мэргэжлийн хөтөч тайлбарлагчдын холбооны зохион байгуулдаг Мэргэжлийн хөтөч тайлбарлагчийн үнэмлэх олгох шалгалтыг сурталчилж ажиллав. | 04-04 | 100 |

ТАЙЛАН ГАРГАСАН:
ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ, ОЛОН НИЙТ ХАРИУЦСАН ................................. 2025.06.05
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН / Б.ЦОЛМОНГЭРЭЛ /

*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 2023 оны 98 дугаар тушаалын*
*5 дугаар хавсралт*

## НЭМЭЛТ ҮҮРЭГ ДААЛГАВАР (АРГА ХЭМЖЭЭ)-ЫН ХУУДАС (ЗАГВАР)

| Д/д | Үүрэг даалгавар | Үүрэг даалгавар өгсөн удирдах албан тушаалтан | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхлэх хугацаа | Дуусах хугацаа |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | **Үүрэг даалгавар1.** Нүүдэлчин өвлийн наадмын үеэр зохион байгуулагдсан Өвлийн дээлтэй монгол жагсаалын хэвлэл, сурталчилгааны ажлыг зохион байгуулах | Газрын дарга | Үйл ажиллагааны Хэрэгжилтийн хувь | - | 2025 оны 02-р сарын 17-ны өдөр Нүүдэлчин өвлийн наадмын үеэр зохион байгуулсан "Өвлийн дээлтэй Монгол" жагсаалын хэвлэл, сурталчилгааны ажлыг зохион байгуулах ажлын хүрээнд байгууллагын цахим хуудсууд болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээ мэдээлэл бэлдэж түгээж ажилласан. | 2025.02.10 | 2025.02.18 |
| 2 | **Үүрэг даалгавар2.** "Наурызын баяр- Нарны баяр" арга хэмжээний хэвлэл мэдээлэл, маркетингийн ажлыг зохион байгуулах | Газрын дарга | Үйл ажиллагааны Хэрэгжилтийн хувь | - | Нийслэлийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын газрын даргын үүрэг болгосны дагуу 2025 оны 03-р сарын 20-ны өдөр жанжин Д.Сүхбаатарын талбайд зохион байгууллаа. Энэ хүрээнд арга хэмжээний хэвлэл мэдээлэл, маркетинг сурталчилгааны ажлыг зохион байгуулж арга хэмжээний өмнө байгууллагын цахим хуудас болон хэвлэл мэдээллийн байгууллагуудад мэдээ мэдээлэл бэлтгэж түгээх болон тухайн өдрүүдэд хэвлэл мэдээллийн байгууллагад мэдээлэл өгч, ярилцлага, | 2025.03.10 | 2025.03.21 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | сурвалжилгад оролцох албаны хүмүүсийг зохион байгуулж ажиллалаа. | | |
| 3 | **Үүрэг даалгавар 3.** Узбек хоолны өдөрлөг арга хэмжээний хэвлэл мэдээлэл, маркетингийн ажлыг зохион байгуулах | Газрын дарга | Үйл ажиллагааны Хэрэгжилтийн хувь | - | Монголд зочлох жилийн хүрээнд Улаанбаатар хотын аялал жуулчлалыг хөгжүүлэх, жуулчны улирлын хамаарлыг бууруулах, шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг бий болгох, хотын соёлыг түгээн дэлгэрүүлэх, иргэдийн амралт чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/176 дугаар захирамж, тус газрын даргын 2025 оны А/06 дугаар тушаалын дагуу 2025 оны 04 дүгээр сарын 08-13-ны өдрүүдэд "UB food-2025" олон улсын хоолны өдөрлөгийг жанжин Д.Сүхбаатарын талбайд зохион байгууллаа. Тухайлбал:<br>- Асрын гадна, доторх хэвлэл<br>- Такс/бугуйвч/ хэвлэлт,<br>- Улаан туузан хаалт түрээс,<br>- Стэнд түрээс<br>- Арга хэмжээний зохион байгуулалтад оролцох албан хаагчдын хувцсан дээрх хэвлэл<br>- Мандат хэвлэлт зэрэг хэвлэлтийн ажлын эх бэлтгэл, дизайн, хэвлэлийн ажлыг зохион байгуулсан.<br><br>Тус арга хэмжээг сурталчлах ажлын хүрээнд байгууллагын цахим хуудас болон хэвлэл мэдээллийн байгууллагуудад мэдээ мэдээлэл бэлтгэж түгээх болон тухайн өдрүүдэд хэвлэл мэдээллийн байгууллагад мэдээлэл өгч, ярилцлага, | 2025.03.20 | 2025.04.15 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | сурвалжилгад оролцох албаны хүмүүсийг зохион байгуулж ажиллалаа. | | |
| 4 | **Үүрэг даалгавар 4.** МВА-ийн тоглолтын хуваарийг судалж, танилцуулах | Газрын дарга | Үйл ажиллагааны Хэрэгжилтийн хувь | - | “Узбек хоолны өдөрлөг”-ийн үеэр олон нийтийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх ажлын хүрээнд дэлгэцээр спортын уралдаан цацах чиглэлээр спортын телевизүүдийн судалгаа гаргаж, Пример спорт суваг телевиздд албан бичиг илгээж, телевизийн хөтөлбөрийг урьдчилж авах болон зөвшөөрөл авч ажиллалаа. | 2025.04.01 | 2025.04.15 |
| 5 | **Үүрэг даалгавар 5.** Улаанбаатар хотын соёлын өдрүүд арга хэмжээний хэвлэл, маркетинг сурталчилгааны ажлыг зохион байгуулах | Газрын дарга | Үйл ажиллагааны Хэрэгжилтийн хувь | - | Унгар Улсын Будапешт хотод 2025 оны 05 дугаар сарын 11,12-ны өдрүүдэд Улаанбаатар хотын соёлын өдрүүд арга хэмжээний маркетинг сурталчилгааны ажлыг зохион байгуулж, Унгар улсын 5 инфлунсэрээр дамжуулан цахим орчинд контент бэлтгэн 1 сая орчим хүнд түгээсэн.<br><br>Арга хэмжээний бэлтгэл ажлын хүрээнд Нийслэлийн Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих төв НӨҮГ-тэй хамтран талбайн тохижуулалтын ажлыг гүйцэтгэж аялал жуулчлалын компаниудын үзэсгэлэнгийн талбай тохижуулалт болон үндсэн талбайн анонс хэвлэлт болон бусад холбогдох тараах материалын хэвлэлтийн ажлыг зохион байгуулсан. Улаанбаатар хотын сурталчилгааны “Улаанбаатар” сэтгүүлийг 1500 ширхгийг хэвлүүлэн тараасан. Унгар Улсад суралцаж буй | 2025.04.01 | 2025.05.15 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | оюутан залуусыг хамруулан Улаанбаатар хотыг сурталчлах ажлыг зохион байгуулсан. Аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчлах зорилгоор богино хэмжээний видео контентуудыг бэлтгэж олон нийтийн сүлжээнд түгээж, ажилласан | | |
| 6 | **Үүрэг даалгавар 6.** Нийслэлийн нийтийн тээврийн газартай хамтран Улаанбаатар хотын аялал жуулчлалын сурталчлах ажлыг зохион байгуулах | Газрын дарга | Үйл ажиллагааны Хэрэгжилтийн хувь | - | Визит Улаанбаатар брэндийг хэрэглээнд нэвтрүүлэх, үйл ажиллагаандаа тогтмол ашиглах үүднээс Нийтийн тээврийн бодлогын газар, Улаанбаатар смарт карт ХХК-д албан хүсэлт өгч зорчигчийн картад хэвлүүлэх хүсэлтийг тавьж Чингис хаан олон улсын нисэх буудлаас гадаад дотоодын жуулчдад үйлчлэх нийтийн тээврийн 7 автобусанд Визит Улаанбаатар, Go Mongolia логог байршуулах ажлыг зохион байгууллаа. Мөн автобусанд мэдээлэл өгөх зориулалттай дэлгэцээр гаргах Улаанбаатар хотын танилцуулга, энэ онд зохион байгуулагдах эвентийн танилцуулга, Go Mongolia -ийн богино бичлэгүүдийг нэгтгэж, илгээж ажиллалаа. | 2025.05.01 | 2025.06.05 |
| 7 | **Үүрэг даалгавар 7.** Улаанбаатар хотын аялал жуулчлалыг сурталчлах ажлыг зохион байгуулах | Газрын дарга | Үйл ажиллагааны Хэрэгжилтийн хувь | - | Польш улсад суугаа Монгол Улсын Элчин сайдын яамнаас хүсэлт тавьсны дагуу Улаанбаатар хотын зурагнуудыг илгээж, сонгогдсон зурагнуудыг өндөр чанартайгаар хэвлүүлэх ажилд хамтарч ажиллалаа. | 2025.04.01 | |
| 8 | **Үүрэг даалгавар 8.** Олон улсын арга хэмжээнд Улаанбаатар хотын аялал жуулчлалыг | Газрын дарга | Үйл ажиллагааны Хэрэгжилтийн | - | Улаанбаатар хотын аялал жуулчлалыг сурталчлах ажлын хүрээнд Гадаад харилцааны яамнаас хүсэлт тавьсны дагуу Монгол улс, | 2025.05.25 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | сурталчлах ажлыг зохион байгуулах | | хувь | | Улаанбаатар хотын зурагнуудаас сонгож, Визит Улаанбаатар, Go Mongolia логог байршуулж, богино хэмжээний бичлэг, танилцуулга видеонуудыг нэгтгэж илгээлээ. | | |
| 9 | **Үүрэг даалгавар 10.** Олон улсын арга хэмжээнд Улаанбаатар хотын аялал жуулчлалыг сурталчлах ажлыг зохион байгуулах | Газрын дарга | Үйл ажиллагааны Хэрэгжилтийн хувь | - | Азийн үнэт цаасны 30 дахь удаагийн чуулганы нэгдсэн хуралдаанд оролцох олон улсын зочид төлөөлөгчдөд Монгол улс, Улаанбаатар хотыг сурталчлах ажлын хүрээнд ашиглах эрхтэй гэрэл зураг, видео контентуудыг нэгтгэн өгч ажиллалаа. | 2025.05.20 | |
| 10 | **Үүрэг даалгавар 11.** Эвент арга хэмжээний маркетинг сурталчилгааны ажлыг зохион байгуулах | Газрын дарга | Үйл ажиллагааны Хэрэгжилтийн хувь | - | “Улаанбаатар травел экспо” дотоодын аялал жуулчлалын үзэсгэлэнгийн маркетинг сурталчилгааны ажлын хүрээнд байгууллагын цахим хуудсыг дагасан оролцогчдод тараах гарын бэлэг гар утасны карт холдер байхаар төлөвлөж, Визит Улаанбаатар логог байршуулах ажлыг зохион байгууллаа. Мөн байгууллагын стэнд тохижуулалтын ажлыг зохион байгуулж, лед стэндний хэмжээнд тохирсон Улаанбаатар хотын аялал жуулчлалын контентыг засаж ажиллалаа. | 2025.05.14 | 2025.05.16 |
| 11 | **Үүрэг даалгавар 12.** Иргэний нисэхийн ойд зориулан постер, шторк бэлтгэж холбогдох хүнд өгөх | Газрын дарга | Үйл ажиллагааны Хэрэгжилтийн хувь | - | Монгол Улсад нисэх хүчин үүсэж хөгжсөний ойд зориулан Улаанбаатар хотын танилцуулга, энэ онд зохион байгуулагдах эвентийн танилцуулга, “Go Mongolia”-ийн богино бичлэгүүдийг нэгтгэж, илгээж ажиллалаа. | 2025.05.16 | |
| 12 | **Үүрэг даалгавар 13.** “Мэжик дрийм” парадын ажлыг сурталчилж | Газрын дарга | Үйл ажиллагааны Хэрэгжилтийн | - | НЗДТГ-аас зохион байгуулсан “Монгол хүүхэд 2025” арга хэмжээний үеэр тус газраас зохион байгуулсан | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | ажиллах | | хувь | | “Мэжик дрийм” баярын жагсаалыг сурталчилж ажиллав. | 2025.06.01 |
| 13 | **Үүрэг даалгавар 14.** Мэргэжлийн хөтөч тайлбарлагчийн үнэмлэх олгох шалгалтыг сурталчилж ажиллав. | Газрын дарга | Үйл ажиллагааны Хэрэгжилтийн хувь | - | Мэргэжлийн хөтөч тайлбарлагчдын холбооны зохион байгуулдаг Мэргэжлийн хөтөч тайлбарлагчийн үнэмлэх олгох шалгалтыг сурталчилж ажиллав. | 2025.04.29 |

**НЭМЭЛТ ҮҮРЭГ ДААЛГАВАР АВСАН:**

Хэвлэл мэдээлэл, олон нийт хариуцсан ахлах мэргэжилтэн ................ /Б.Цолмонгэрэл / 2025.06.05

**ХЯНАН БАТАЛГААЖУУЛСАН:**

Мэдээлэл сурталчилгааны хэлтсийн дарга ................ / Н.Алтанзаяа / 2025.06.10